



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/10

Хужирт сум


Цалин шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 5, 7, 8 дугаар хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”, 2019 оны А/854 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, удирдах албан тушаал эрхэлж байгаа багшид Мэргэжлийн зэрэг олгох, хасах, мэргэжлийн зэргийг хэвээр хадгалах журам”, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн шууд захирагч нарын 2020 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан цалинг хавсралтаар баталсугай.

2. Шинэчилсэн баталсан цалинг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн тооцон олгохыг тухай байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ